

Ерөнхийлөгч
Хэнри Б.Айринг

Тэргүүн Зөвлөлийн
нэгдүгээр зөвлөх



Тань, сана, мөн талархлаа илэрхийл

Бурханаас хүлээн авсан бүхий л адислалуудынхаа төлөө Түүнд талархаж байхыг Тэрээр биднээс хүсдэг. Бид Бурханд зүрх сэтгэлийн бэлэг болгон өргөх талархлаа анхаарахгүйгээр, ижил үгсийг олон удаа давтсанаар бидний талархлын залбирлууд нэгэн хэвийн, энгийн болдог. Бид “. . . талархлаа Сүнсээр илэрхийлэх” (С ба Г 46:32) юм бол Бурханы бидэнд өгсөн зүйлсийн төлөө жинхэнэ талархлыг мэдрэх болно.

Бидний төлөө Бурханы хийсэн тэр бүх зүйлсийн нэгээхэн хэсгийг ч гэсэн бид хэрхэн санаж чадах вэ? Ариун Сүнсний бэлгээр дамжин ирдэг санах бэлгийн тухай Аврагч бидэнд хэрхэн заасныг төлөөлөгч Паул “Харин Туслагч буюу Миний нэрээр Эцэгийн минь илгээх Ариун Сүнс та нарт бүх зүйлсийг заах бөгөөд Миний та нарт хэлсэн бүгдийг сануулах болно” (Иохан 14:26) хэмээн цэдэглэсэн байдаг.

Ариун Сүнс бидэнд заасан Бурханы зүйлсийн дурсамжуудыг сэргээдэг. Бурханы бидэнд заадаг аргуудын нэг нь Түүний адислалууд юм. Тиймээс, хэрэв бид итгэлээ хөгжүүлэхийг сонговол Ариун Сүнс бидэнд Бурханы хайрыг сануулах болно.

Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсон (1899–1994) тэрхүү залбирлыг хийхэд цаг хугацаа гаргадгийг онцолсон. Тэрээр “Бошиглогч Иосеф Смит нэгэн удаа хэлэхдээ,

Хожмын үеийн гэгээнтнүүдийн томоохон нүглүүдийн нэг бол талархалгүй байдлын нүгэл юм. Миний бодлоор, бидний ихэнх нь үүнийг том нүгэл гэж ер боддоггүй байх. Бид Их Эзэнээс өөрсдийн гуйлт, залбирлууддаа нэмэлт адислалуудыг хүсэх хандлага их байдаг. Харин бид залбирлууддаа аль хэдийн хүлээн авсан адислалуудынхаа төлөө баярлаж, талархах үгсээ байнга илэрхийлэхэд арай илүү цаг зориулах хэрэгтэй гэж би боддог. Бид маш их сэтгэл ханамжийг авах болно”¹ хэмээн хэлсэн юм.

Та Ариун Сүнсний бэлгээ ашиглан өнөөдөр ч ийм туршлагыг олж авч болох юм. Хувиараа талархлын залбирал хийн, үүнийг эхэлж болно. Та адислалууддаа тоолж эхлэн, тэгээд хэсэг чимээгүй азна. Хэрэв та Ариун Сүнсний бэлгээр итгэлээ хөгжүүлбэл таны оюун санаанд бусад адислалуудын тань талаарх дурсамжууд урсан ирэх болно. Та тэр болгоны төлөө талархлаа илэрхийлж эхэлснээр залбирал тань ердийнхөөсөө арай урт болж магадгүй. Дурсамжууд сэргэн, мөн талархах болно.

Та яг ийм зүйлийг тэмдэглэдээ бүртгэн бичиж болно. Ариун Сүнс хүмүүст эдгээр зүйлсийг хийхэд нь цагийн эхлэлээс хойш тусалсаар байгаа. Мо-сегийн номд “Мөн Адамын хэл дээр цэдэглэгдсэн дурсамжийн ном хөтлөгдөж байв, учир нь бурханлаг

нөлөөний сүнсээр бичихийн тулд Бурханыг дуудсан болгонд энэ нь өгөгдсөн байлаа” хэмээсэн байдгийг та нар мэднэ (Мосе 6:5).

Ерөнхийлөгч Спэнсэр В.Кимбалл (1895–1985) сүнслэгээр өдөөсөн бичээсүүдийн талаар хэлэхдээ: “Дурсамжийн номыг хөтөлдөг тэдгээр хүмүүс амьдралынхаа өдөр тутамд Их Эзэнийг санаж байдаг. Тэмдэглэл хөтлөх нь адислалуудаа тоолох, мөн үр удамдаа эдгээр адислалуудынхаа тэмдэглэлийг үлдээх нэгэн арга зам юм” гэжээ.²

Бичиж эхлэхдээ та өөрөөсөө “Бурхан өнөөдөр намайг болоод хайртай тэднийг минь хэрхэн адислав?” гэж асууж болно. Хэрэв та үүнийг итгэлтэйгээр тогтмол хийх юм бол та адислалуудаа санах болно. Заримдаа таны оюунд тэдгээр бэлгүүд өдрийн турш мэдэгдэхгүй мэт байж болох ч Бурханы гар таны амьдралд хүрч нөлөөлснийг дараа нь та мэдэх болно.

Тэнгэрлэг Эцэг болон Аврагч маань биднийг Тэдэн рүү, гэр рүүгээ очих үүдийг нээхийн тулд юу хийснийг болон хийж буйг бид итгэлтэйгээр үргэлжлүүлэн, хичээн чармайснаараа таньж, санаж, мөн талархлаа илэрхийлж байхын төлөө би залбирч байна.

ТЭМДЭГЛЭЛҮҮД

1. Эзра Тафт Бэнсон, *God, Family, Country: Our Three Great Loyalties* (1974), 199.
2. Спэнсэр В.Кимбалл, “Listen to the Prophets,” *Ensign*, 1978 оны 5-р сар, 77.

ЭНЭ ЗАХИАСААС ЗААХ НЬ

Энэхүү захиасдаа Ерөнхийлөгч Айринг биднээс залбиралдаа Тэнгэрлэг Эцэгийн хайрыг санаж байхыг хүссэн. Талархалтайгаар залбирах нь амьдралд маань ирсэн Бурханы нөлөөллийг танихад бидэнд хэрхэн тусалдаг талаар заадаг хүмүүстэйгээ ярилц. Та заадаг тэдгээр хүмүүстэйгээ өвдөг сөгдөн залбирах мөн зөвхөн талархлаа илэрхийлсэн залбирал хэлэхийг санал болгох талаар бод.

Та нар талархал чухал болох талаар суралцахдаа Ерөнхийлөгч Айрингийн сануулсан шүлгүүд дээр нэмж дараах шүлгүүдийг уншин судалж болно: Дуулал 100; Мозая 2:19–22; Алма 26:8; 34:38; Сургаал ба Гэрээ 59:21; 78:19; 136:28.

ӨСВӨР ҮЕИЙНХЭНД

Жагсаалт хийх

Ерөнхийлөгч Айринг “Тэмдэглэл хөтлөх нь адислалуудаа тоолох, мөн үр удамдаа эдгээр адислалуудынхаа тэмдэглэлийг үлдээх нэгэн арга зам юм” хэмээсэн Ерөнхийлөгч Спэнсэр В.Кимбаллын (1895–1985) үгнээс эш татжээ. 2012 оны намрын чуулган дээр Ерөнхийлөгч Томас С.Монсон тэмдэглэл хөтлөх тухай гэрчлэлээ хэлсэн юм. Тэрээр амьдралынхаа туршлагаас хуваалцан, “Миний олон жилийн турш хөтөлсөн өдрийн тэмдэглэл надад эргэн санах, өөр хаанаас ч олж чадахгүй тийм зүйлсээр онцгой чухал ажлаа хэрэгжүүлэхэд минь тусалсан” гээд тэрээр, “Амьдралынхаа бичээсийг хөтөл, ялангуяа хүлээн авсан том, жижиг адислалуудаа онцгойлон бич” хэмээн зөвлөжээ. (“Адислалуудаа тунгаан бод,” *Лиахона* буюу *Ensign*, 2012 оны 11-р сар, 86). Эдгээр бошиглогчдын зөвлөгөөг даган тэмдэглэл хөтлөх зорилго тавь.

ХҮҮХДҮҮДЭД ЗОРИУЛАВ

Баярласнаа хэлэх олон аргууд

“Дэлхий даяар энэ өдрийн төгсгөлд Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүд өвдөг сөгдөн залбирч, хүн бүр өөрийн өвөрмөц арга замаар баярласнаа илэрхийлдэг.”

“Дэлхийн бүх хүүхдүүд,” Хүүхдийн дууны ном, 16.
Газрын зураг ашиглан эдгээр хэлээр аль орнуудад
ярьдгийг олж мэд. Эдгээрээс зарим хэлээр нь нэгээс
илүү олон орнуудад ярьдаг!

1. грасиас (испани)
2. мало (тонга)
3. тэнк ю (англи хэл)
4. шукрияа (хинди)
5. спасибо (орос)
6. аригато (япон)
7. обригадо (португали)
8. асанте (свахили)
9. мерси (франц)



Халамж

Энэ материалыг залбирч судлан гэрт нь очиж заадаг эгч нартайгаа аль болох ойлгомжтойгоор яриц. Эгч нарыг хүчирхэгжүүлэх болон Нийгмийн Халамжийн Бүлэг өөрийн тань амьдралд идэвхтэй үүрэг гүйцэтгэхэд туслах асуултуудыг асуу. Нэмэлт мэдээллийг reliefsociety.lds.org-ээс үзнэ үү.

Сүмийн халамжийн зорилго нь гишүүдэд бие даах чадвартай болоход мөн гачигдсан, тусламж хэрэгтэй хүмүүст тусалж үйлчлэх явдал юм. Халамж нь Нийгмийн Халамжийн Бүлгийн үндсэн гол ажил. Тэргүүн Зөвлөлийн нэгдүгээр зөвлөх Ерөнхийлөгч Хэнри Б. Айринг заахдаа:

“Цагийн эхлэлээс л [Их Эзэн] Өөрийн дагалдагчдаа туслах арга замаар хангаж байсан. Тэрээр хүүхдүүдээ цаг зав, мөнгө хөрөнгө, өөрийгөө золиослон бусдад үйлчлэхэд түүнтэй нэгдэхийг урьдаг. . . .

“Тэрээр гачигдсан нэгнийг өргөн босгох Өөрийн ажилд оролцоход биднийг урьдаг ба мөн бидэнд зааварладаг. Бид баптисмын усанд мөн ариун сүмүүдэд эдгээр ажлыг хийх гэрээ хийдэг. Ням гарагт бид ариун ёслолын цуглаанд оролцохдоо энэхүү гэрээгээ шинэчилдэг”¹ гэсэн юм.

Бишоп эсвэл салбарын ерөнхийлөгчийн удирдлага дор орон нутгийн удирдагчид нь сүнслэг болоод материаллаг халамжийг хэрэгжүүлдэг. Айлчлагч багш нар айлчлан очдог эгч бүрийн

хэрэгцээг сүнслэгээр эрэлхийлснээр үйлчлэх боломжууд эхэлдэг.

Судруудаас

Лук 10:25–37; Иаков 1:27; Мозая 4:26; 18:8–11; Сургаал ба Гэрээ 104:18

Бидний түүхээс

1842 оны 6-р сарын 9-нд Бошиглогч Иосеф Смит Нийгмийн Халамжийн эгч нарт “ядарсныг тэтгэх” мөн “бодгалиудыг аврах” үүргийг өгсөн.² Эдгээр үүргүүд одоо ч мөн Нийгмийн Халамжийн мөн чанар нь болж, бидний “Энэрэл хэзээ ч дуусдаггүй” хэмээх урианд илэрхийлэгдэж байдаг (1 Коринт 13:8).

Манай Нийгмийн Халамжийн тав дахь ерөнхий Ерөнхийлөгч Эммилайн Б.Уэйлс болон түүний зөвлөхүүд 1913 онд бидний суурь зарчмуудыг сануулагч “Бошиглогч Иосеф Смитийн илчлэлтийн дагуу санваарын удирдлагаар хүчирхэгжин зохион байгуулагдсан энэ байгууллагын эмэгтэйчүүд бид өвдсөнийг анагааж, гачигдсанд туслах, настныг тайвшруулж, залхууг сэрэмжлүүлэх, бэлэвсэрч

өнчрөгсдийг дэмжин туслах зорилгодоо тууштай чанд байхаа тунхаглаж байна” гэсэн уриаг гаргажээ.³

Өнөөдөр Нийгмийн Халамжийн Бүлэг дэлхий даяарх эгч нараар энэрэл болон Христийн цэвэр хайрыг өөрсдийнх нь хөршүүдэд хүргэж байна (Моронай 7:46–47-г үзнэ үү).

Эшлэлүүд

1. Хэнри Б.Айринг, “Сайныг үйлдэх боломжууд,” *Лиакхона* ба *Ensign*, 2011 оны 5-р сар, 22.
2. Иосеф Смит, *Миний хаант улсын охид: Нийгмийн Халамжийн түүх ба ажил* (2011), 63.
3. *Миний хаант улсын охид*, 63.

Би юу хийж чадах вэ?

1. Би өөртөө мөн гэр бүлдээ сүнслэг болон материаллаг байдлын хувьд санаа тавихад хэрхэн бэлтгэж байгаа вэ?
2. Харж ханддаг эгч нарынхаа зохих хэрэгцээнд нь туслахын тулд Аврагчийн жишээг би хэрхэн дагаж болох вэ?